БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

**БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ**

17042 Улаанбаатар хот , Хан-Уул дүүрэг, 3-р хороо,
Б.Шаравын гудамж-6, Хан-Уул тауэр, 1201 тоот
Утас: +976-70140166, 70140188,
Э-шуудан: piubaccp@gmail.com,
http://www.baccp.mn

2025. 07. 03 № 25/32

танай ______________ -ны № ______________ -т

БАЙГАЛЬ ОРЧИН,
УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.ДЭЛГЭРБАТ ТАНАА

Үйл ажиллагааны 2025 оны
хагас жилийн тайлан
хүргүүлэх тухай

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III” төслийн 2025 оны “Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн” хагас жилийн тайланг Засгийн газрын 2025 оны 13 дугаар тогтоолын дагуу “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын дагуу Байгууллагын үйл ажиллагааны үнэлгээ хийх журам”-ийн хавсралт-3 дагуу боловсруулан, хүргүүлж байна.

Хавсралт ..17.. хуудастай

Хувийг: Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газар,
Хяналт үнэлгээ, аудитын газарт

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ М.ТУЛГА

УЛААНБААТАР ХОТ
БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ
ТБАГ
9020070899 рд 6599737

ЗГ-ын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн
А/43 дугаар тогтоолын "Байгууллагын үйл ажиллагаа,
үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 4 дүгээр хавсралт

# БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

(2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар)

| д/д | Үзүүлэлт | |
|---|---|---|
| | 1 | 2 |
| | **Төсөл, арга хэмжээний агуулга** | **Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт** |
| 1 | **Төсөл хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар** | **Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II/III төсөл**<br>**Шийдвэр:**<br>**БОЯБХУАӨДЗ II төсөл:** Монгол-Германы Засгийн газар хооронд 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээр<br>**БОЯБХУАӨДЗ III төсөл:** Монгол-Германы Засгийн газар хооронд 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээр<br>**Төслийн дугаар: BMZ 2016 67 054; BMZ 2018 68 272**<br>**Төслийн зорилго:** Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн болон нийлмэл/ холбоос нутгуудын (орчны бүс болон экологийн коридор, кластер) тогтвортой, үр дүнтэй менежментийг бэхжүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, орчны бүс дэх орон нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжихэд оршино. |
| 2 | **Санхүүжилтийн эх үүсвэр** | ХБНГУ-ын Засгийн газар **Буцалтгүй тусламж**<br>Монгол Улсын Засгийн газар |
| 3 | **Хэрэгжүүлэгч байгууллага/ нийт хэрэгжих хугацаа** | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БОУАЯ, Төсөл хэрэгжүүлэх нэгж, Зөвлөх баг |
| | | Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам, БОАЖЯ-ны ТХГНБЗГ, ТХГН-ийн хамгаалалтын захиргаад, байгаль орчны газрууд |
| | | Хэрэгжих хугацаа: 7 жил: 2020.03 сар – 2027.03 сар /II, III үе шат/ |
| 4 | **Төсөл хөтөлбөрийн зорилтууд** | **Зорилт 1:** Тусгай хамгаалалттай газрын менежмент төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах;<br>**Зорилт 2:** Баруун бүсийн байгаль орчны байгууллагуудын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;<br>**Зорилт 3:** Менежментийн онцлог хэрэгцээ бүхий бие даасан долоон тусгай хамгаалалттай газрыг тогтоосон шалгуурын дагуу |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | сонгож менежментийн болон бизнес төлөвлөгөөг нь сайжруулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх; **Зорилт 4:** Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний хэмжээнд чадавхыг дээшлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах арга хэмжээнүүдийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх; | | | |
| 5 | Зардал | Төсөв (нийт төсөв) | Төслийн II,III шатны нийт төсөв 32.8 сая евро. ХБНГУ-ын Засгийн газар 27.5 сая евро, Монгол Улсын Засгийн Газар 14.8 тэрбум төгрөг | | |
| 6 | Үүнд: | Төсөв (2025 он) | Гүйцэтгэл (2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар) | | Хувь |
| | | Төгрөгөөр | Евро | Төгрөг | |
| 7 | ХБНГУ-ын ЗГ | 21,260,000,000.00 | 125,988.00 | 501,677,105.09 | 2.4% |
| 8 | МУ-ын ЗГ | 1,317,977,000.00 | | 390,376,857.87 | 30% |
| 9 | Төсөл хөтөлбөрийн зорилт: | 2025 оны үйл ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөний дагуу биелэлтийг гаргав. (*Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр баталгаажсан тул ҮАТ-нд туссан ажлуудыг үнэлэх боломжгүй учир он дамнан хэрэгжсэн болон бусад төслийн ерөнхий менежмент үйл ажиллагааны хүрээнд хийсэн ажлуудын биелэлтийг тайлагнасан болно*). | | | |
| 10 | 1-дүгээр зорилтын хүрээнд | *Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем* *6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.* **1.01 Аймгийн БОАЖГ-уудыг үндсэн тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд /ҮАТ 1.02./:** БОАЖЯ-ны ТНБД-ын 2024.06.06 №А/256 тушаалын дагуу тендерийн үнэлгээний хороог байгуулж, сонгон шалгаруулалтыг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан. Тендерийн ялагч "АйСиАй Систем Монголиа" ХХК-тай 562,576,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий №24/409 дугаартай гэрээг 2024.09.24 өдөр байгуулсан. Барааны дээж танилцуулах уулзалтыг тус өдөр зохион байгуулж, бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн захиалга, үйлдвэрлэл явагдаж, тээвэрлэлтэд шилжүүлээд байна. Гэрээний дагуу эхний төлбөрийг 2024.12.27-ны өдөр хийсэн. Тоног төхөөрөмжийн ашиглалтын сургалтыг 2025.01.30-ны өдөр зохион байгуулж, дэд актаар 16 аймгийн БОГ-т хүлээлгэн өгсөн. Гүйцэтгэлийг хангуулж гэрээг 2025.03.06-ны өдрөөр дүгнэж баталгаажуулсан. **Ажлын гүйцэтгэл 100%.** | | | 95 |

| | | | |
|---|---|---|---|
| | | **1.02 Аймгийн БОАЖГ-уудыг дүрэмт хувцсаар хангах ажлын хүрээнд /ҮАТ 1.03/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2024.06.24 №А/291, 2024.09.09 №А/372 тушаалын дагуу тендерийн үнэлгээний хороог байгуулж, сонгон шалгаруулалтыг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан.<br>Тендерийн ялагч ""Асралтбаян Хайрхан" ХХК-тай €533,461.92 үнийн дүн бүхий №24/487 дугаартай гэрээг 2024.12.03 өдөр байгуулсан. Гэрээгээр нийлүүлэх 1,964,878,958.33 төгрөгийн үнийн дүн бүхий 17 нэр төрлийн 9758 ширхэг хувцас хэрэглэл хүлээн авахаас 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр эхний 60 хувийн гүйцэтгэлд хамаарах 10 нэр төрлийн 6444 ширхэг хувцас хэрэглэлийг 2025.05.02-ны өдрийн 2025/09 дүгээр актаар хүлээн авав. Төсөл хэрэгжиж буй газруудад 2025 оны 06 дугаар сарын 25-26 өдрүүдэд актаар хүлээлгэн өгсөн. Эхний санхүүжилтийн хүсэлтэд хамаарах холбогдох баримтуудыг 2025.05.12-ны өдөр санхүүгийн ажилтанд шилжүүлэв. Эцсийн гүйцэтгэл хангагдсан тухай мэдэгдлийг 2025.05.28-ны өдөр захиалагчид ирүүлээд байна. **Ажлын гүйцэтгэл 90%,**<br><br>**1.03 9 ТХГН-ийн МТ боловсруулах ажлын хүрээнд /ҮАТ 1.04./:**<br>Төслийн зөвлөх багийн гүйцэтгэх тус ажил нь нийт 9 төлөвлөгөө боловсруулахаас Дарьганга, Их газрын чулууны БЦГ-уудын төлөвлөгөөнүүд 2026 онд дуусах, Хомын талын БЦГ өөрсдөө боловсруулсан тул Говийн Бага, Говийн Их Б ДЦГ, Монгол Элс, Хөх Сэрхийн нуруу, Цамбагарав уул, Их Богдын БЦГ-ын нийт 6 төлөвлөгөөг боловсруулж байна. 5 төлөвлөгөөний ажлын гэрээг богино хугацааны зөвлөхүүдтэй байгуулсан. 2025 оны 1-р сарын 29–30-нд ҮБХЗ-аас Хөх Сэрхийн нуруу ТХГН болон Цамбагарав уулын БЦГ-ын менежментийн төлөвлөгөөг боловсруулах анхны семинарыг зохион байгуулсан. 1 төлөвлөгөөний ажлын гэрээг байгуулахаар ажиллаж байна. Нийт 27 ТХГН-ийн 14 нь хүчин төгөлдөр менежментийн төлөвлөгөөтэй (үүнээс 7-ыг төслийн II/III үе шатанд шинэчилсэн); 2 ТХГН-д төслийн дэмжлэгтэйгээр төлөвлөгөө боловсруулагдаж байна; 5 ТХГН нь орон нутгийн БНГ болон БДГ ангилалтай тул менежментийн төлөвлөгөө шаардлагагүй. **Ажлын гүйцэтгэл 50%, Үнэлэх боломжгүй, хугацаа болоогүй.** | |
| | 2-дугаар зорилтын хүрээнд | *Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин*<br>*2.5.2. Орон сууцны чанар, стандартыг ханган, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.* | |

| | | | |
|---|---|---|---|
| 11 | | *2.5.4. Орон сууцны халаалт, эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.*<br>*2.5.6. Ногоон байгууламжийн усалгаанд хур тунадасны болон саарал усыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.*<br><br>**2.01 Цаг уурын автомат станцаар хангах (Говь-Алтай - 2, Ховд-2) ажлын хүрээнд /ҮАТ 2.16/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2024.06.24-ний өдрийн №А/256 тушаалын дагуу тендерийн үнэлгээний хороог байгуулж, сонгон шалгаруулалтыг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан.<br>Тендерийн ялагч "АЧСВС" ХХК-тай 432,440,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий №24/399 дугаартай гэрээг 2024.09.10 өдөр байгуулсан. Гүйцэтгэлийг 2025.01.27-30-ны өдрүүдэд гүйцэтгэж, тайланг 2025.02.07-ны өдөр ирүүлсэн. Гэрээний дагуу Ховд, Говь-Алтай аймгуудын ЦУОШТөвүүдэд тус бүр 2 ширхэг, нийт 4 ширхэг цаг уурын автомат станцыг хүлээлгэн өгч холбогдох сургалтыг зохион байгуулсан тул гүйцэтгэл бүрэн хангагдсан гэж үзэж гэрээг дүгнэн, санхүүжилтийн хүсэлт болон холбогдох баримтуудыг 2025.02.18-ны өдөр санхүүгийн ажилтанд шилжүүлсэн.<br>**Ажлын гүйцэтгэл 100%**<br><br>**2.02 Хяргас нуурын БЦГ-ын (Увс аймгийн Завхан сум) орчны бүсэд перевоз барих хэрэгцээ шаардлага, үзэл баримтлалыг боловсруулах ажлын хүрээнд /ҮАТ 2.21/**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2024.09.09-ны №А/371 тушаалын дагуу тендерийн үнэлгээний хороог байгуулж, сонгон шалгаруулалтыг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан. Тендерийн ялагч "Дөрвөн тэнхлэг" ХХК-тай ажлын гэрээг 2024.11.28 өдөр байгуулсан. Гүйцэтгэгчээс зөвлөх үйлчилгээний эхлэлийн тайланг 2024.12.25-ны өдөр боловсруулан ирүүлснийг талуудад /БОУАӨЯ, Төслийн зөвлөх баг, ТХН/ хүргүүлж актаар хүлээн авав. Эхний санхүүжилтийг 2025.02.07-ны өдөр олгосон. Эцсийн тайланг 2025.02.20-ны өдөр ирүүлснийг хянаж сайжруулахыг шаардаж холбогдох арга хэмжээг авсанаар эцсийн тайлан хүлээн авах хурлыг 2025.04.17-ны өдөр зохион байгуулж, захиалагч гүйцэтгэлийг 2025/06 дугаар актаар хүлээн авсан. Гүйцэтгэлийг хангуулж гэрээг 2025.04.22-ны өдрөөр дүгнэж баталгаажуулсан. **Ажлын гүйцэтгэл 100%, хоцрогдолтой, 2025 он руу шилжсэн.**<br><br>**2.03 Байгаль хамгаалагчийн байрны барилгын нэг маягийн зураг төсөл, зардлын тооцоог боловсруулах ажлын хүрээнд /ҮАТ 2.03, 3.02/:**<br>2023 онд сонгон шалгаруулалтыг явуулж, "Бьюлдингс технложи" ХХК-тай 2024.01.16-ны өдөр байгуулсан | 92,5 |

| | | | |
|---|---|---|---|
| | | №24/19 тоот 73,298,090.00 төгрөгийн үнийн дүн бүхий зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу гүйцэтгэгч нь барилгын эскиз зургийг захиалагчаар баталгаажуулсан. Төслийн зөвлөх багаас ирүүлсэн нэмэлт сайжруулалттай холбогдуулан гэрээнд нэмэлт өөрчлөлтийг 2024.08.26-нд Гэрээний нэмэлт өөрчлөлтөөр үнийг дүн 118,810,173.0 төгрөг, хугацааг 90 хоногоор буюу 2024.11.27 хүртэл сунгасан. Ажлын даалгаварт өөрчлөлт орсонтой холбогдуулан 2024.12.03-ны өдрийн ТХН болон ЗБ-ийн хамтарсан хурлаар тус гэрээг дахин сунгах саналыг зөвлөх багаас тавьснаар тус ажил хойшилж 2025 он руу шилжсэн. Гүйцэтгэгчээс ирүүлсэн хүсэлт болон төслийн зөвлөх багаас ирүүлсэн саналыг үндэслэн ажил гүйцэтгэх хугацааг 2025.04.01-ний өдөр хүртэл сунгаж гэрээний нэмэлт өөрчлөлтөөр баталгаажуулсан. Төслийн зөвлөх багийн Олон улсын барилгын зөвлөх Георг Пэйбигт зурагт төсвийн сүүлийн хувилбарыг илгээж санал авснаар Барилгын хөгжлийн төвөөр хянуулж баталгаажуулахаар 2025 оны 05 дугаар сард илгээгээд байна. Гэрээгээр ажил гүйцэтгэх хугацаа дуусаж, алданги тооцох нөхцөл бүрдсэн.<br>**Ажлын гүйцэтгэл 90%, хоцрогдолтой.**<br><br>**2.06 Говийн Их ДЦГ-ын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны барилгын одоогийн зураг төсөл, зардлын тооцоог шинэчлэх ажлын хүрээнд /ҮАТ**<br><br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2024.02.29-ний №А/62 тушаалын дагуу тендерийн үнэлгээний хороог байгуулж, сонгон шалгаруулалтыг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан. Тендерийн ялагч "Инженеринг суппорт сервис" ХХК-тай 54,500,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий 24/379 дугаартай гэрээг 2024.06.04 өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу байгаль хамгаалагчийн байрны эскиз зургийг захиалагчаар баталгаажуулах ажил явагдаж байна. Ажлын даалгаварт өөрчлөлт орсонтой холбогдуулан 2024.12.03-ны өдрийн ТХН болон ЗБ-ийн хамтарсан хурлаар тус гэрээг дахин сунгах шийдвэр гарсан. Гүйцэтгэгчээс ирүүлсэн хүсэлт болон төслийн зөвлөх багаас ирүүлсэн саналыг үндэслэн ажил гүйцэтгэх хугацааг 2025.04.01-ний өдөр хүртэл сунгаж гэрээний нэмэлт өөрчлөлтөөр баталгаажуулсан. Төслийн зөвлөх багийн Олон улсын барилгын зөвлөх Георг Пэйбигт зурагт төсвийн сүүлийн хувилбарыг илгээж санал авснаар Барилгын хөгжлийн төвөөр хянуулж баталгаажуулахаар 2025 оны өдөр илгээгээд байна. Гэрээгээр ажил гүйцэтгэх хугацаа дуусаж, алданги тооцох нөхцөл бүрдсэн. **Ажлын гүйцэтгэл 80%,** | |

| | | | |
|---|---|---|---|
| | | **2.10 Алсын удирдлагатай камер, нарны зайн хураагуур хэрэгцээ шаардлагыг тодорхойлох ажлын хүрээнд /ҮАТ 210, 3.04/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2024.06.12 №А/275 тушаалын дагуу тендерийн үнэлгээний хороог байгуулж, сонгон шалгаруулалтыг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан.<br>БОУАӨЯ-ны ТНБД-ын 2024.11.22 №24/389 тушаалын дагуу тендерийн ялагч " Дүйнхэр тэргүүн" ХХК-тай 60,610,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий №24/214 дугаартай гэрээг 2024.09.09 өдөр байгуулсан. Эхлэлийн тайланг 2024.11.20-ны өдөр хүлээн авч 2024.12.04-ний өдрийн 2024/21 дугаартай актаар хүлээн авсан. Гүйцэтгэгчээс эцсийн тайланг 2024.12.10-ны өдөр ирүүлж, шаардлага хангаагүй тул талуудын уулзалтыг 2025.03.07-ны өдөр талууд уулзаж, дахин сайжруулахыг шаардаж, алданги тооцохыг мэдэгдэж, орон нутагт ажиллахаар болсон. Эцсийн тайлан хэлэлцэх хүлээн авах хурлыг 2025.04.25 болон 2025.05.01-ний өдрүүдэд зохион байгуулж, тайланг хүлээн авахаар шийдвэрлэсэн. Эцсийн тайланг 2025.05.05-ны өдөр захиалагчид ирүүлсэн. Тайлан хүлээн авсан актыг баталгаажуулах, Зөвлөх багийн саналыг авах ажлууд явагдаж байна. Гэрээний дагуу гүйцэтгэл хангагдаагүй хугацааны алдангийг тооцож, гэрээ дүгнэсэн актыг баталгаажуулахаар бэлтгэж байна. **Ажлын гүйцэтгэл 90%, хоцрогдолтой.** | |
| 12 | 3- дугаар зорилтын хүрээнд | *Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин*<br>*2.5.2. Орон сууцны чанар, стандартыг хангах, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.*<br>*2.5.4. Орон сууцны халаалт, эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.*<br>*2.5.6. Ногоон байгууламжийн усалгаанд хур тунадасны болон саарал усыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.*<br><br>**1. Байгаль хамгаалагчийн байрны барилгын нэг маягийн зураг төсөл, зардлын тооцоог боловсруулах ажлын хүрээнд /ҮАТ 2.10, 3.01/:**<br><br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2024.02.29-ны №А/62 тушаалын дагуу тендерийн үнэлгээний хороог байгуулж, сонгон шалгаруулалтыг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан.<br>Тендерийн ялагч "Инженеринг суппорт сервис" ХХК-тай 54,500,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий №24/379 дугаартай гэрээг 2024.06.04 өдөр байгуулсан. Тус | 90 |

| | | | |
|---|---|---|---|
| | | гэрээний дагуу байгаль хамгаалагчийн байрны эскиз зургийг захиалагчаар баталгаажуулах ажил явагдаж байна. Ажлын даалгаварт өөрчлөлт орсонтой холбогдуулан 2024.12.03-ны өдрийн ТХН болон ЗБ-ийн хамтарсан хурлаар тус гэрээг дахин сунгах саналыг зөвлөх багаас тавьснаар тус ажил хойшилж 2025 он руу шилжсэн. Гүйцэтгэгчээс ирүүлсэн хүсэлт болон төслийн зөвлөх багаас ирүүлсэн саналыг үндэслэн ажил гүйцэтгэх хугацааг 2025.04.01-ний өдөр хүртэл сунгаж гэрээний нэмэлт өөрчлөлтөөр баталгаажуулсан. Төслийн зөвлөх багийн Олон улсын барилгын зөвлөх Георг Пэйбигт зурагт төсвийн сүүлийн хувилбарыг илгээж санал авснаар Барилгын хөгжлийн төвөөр хянуулж баталгаажуулахаар 2025 оны 05 дугаар сард илгээгээд байна. Гэрээгээр ажил гүйцэтгэх хугацаа дуусаж, алданги тооцох нөхцөл бүрдсэн. **Ажлын гүйцэтгэл 90%, хоцрогдолтой.**<br><br>**3.05 Алсын удирдлагатай камер, нарны зайн хураагуур хэрэгцээ шаардлагыг тодорхойлох ажлын хүрээнд /ҮАТ 2.04, 3.04/:**<br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2024.06.12 №А/275 тушаалын дагуу тендерийн үнэлгээний хороог байгуулж, сонгон шалгаруулалтыг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан.<br>БОУАӨЯ-ны ТНБД-ын 2024.11.22 №24/389 тушаалын дагуу тендерийн ялагч "Дүйнхэр тэргүүн" ХХК-тай 60,610,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий №24/214 дугаартай гэрээг 2024.09.09 өдөр байгуулсан. Эхлэлийн тайланг 2024.11.20-ны өдөр хүлээн авч 2024.12.04-ний өдрийн 2024/21 дугаартай актаар хүлээн авсан. Гүйцэтгэгчээс эцсийн тайланг 2024.12.10-ны өдөр ирүүлж, шаардлага хангаагүй тул талуудын уулзалтыг 2025.03.07-ны өдөр талууд уулзаж, дахин сайжруулахыг шаардаж, алданги тооцохыг мэдэгдэж, орон нутагт ажиллахаар болсон. Эцсийн тайлан хэлэлцэх хүлээн авах хурлыг 2025.04.25 болон 2025.05.01-ний өдрүүдэд зохион байгуулж, тайланг хүлээн авахаар шийдвэрлэсэн. Эцсийн тайланг 2025.05.05-ны өдөр захиалагчид ирүүлсэн. Тайлан хүлээн авсан актыг баталгаажуулах, Зөвлөх багийн саналыг авах ажлууд явагдаж байна. Гэрээний дагуу гүйцэтгэл хангагдаагүй хугацааны алдангийг тооцож, гэрээ дүгнэсэн актыг баталгаажуулахаар бэлтгэж байна. **Ажлын гүйцэтгэл 90%, хоцрогдолтой.** | |
| | 4 дүгээр зорилтын хүрээнд | **4.03 Хамгаалалтын захиргаанд нийлүүлсэн хөрөнгөд хяналт-шинжилгээ хийх, хариуцсан мэргэжилтнүүдэд төслийн мониторингийн сургалт** | |

| | | | |
|---|---|---|---|
| 13 | | **зохион байгуулах /ҮАТ 4.03/:**<br>Төслийн үйл ажиллагааны холбоотой ХШҮ-ний системийг хэрэгжүүлэхтэй холбоотой чадавх бэхжүүлэх сургалтуудыг цогц байдлаар зохион байгуулах юм. Энэ хүрээнд Олон улсын зөвлөх хатагтай Фридрика Лемме 2025 оны гуравдугаар сард Монгол Улсад хүрэлцэн ирж, дээрх сургалтуудыг Өмнөд болон Баруун бүсийн холбогдох ТХГН-ийн төлөөллийг хамруулан амжилттай зохион байгуулсан болно. ТХГН-ийн хамгаалалтын захиргаадын ХШҮ хариуцсан ажилтнуудын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор зөвлөх баг сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн. Энэхүү чадавхыг бэхжүүлэх сургалтыг 2025 оны гуравдугаар сарын 10–20-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд сургалтууд Өмнөд болон Баруун бүсийн төвд зохион байгуулагдаж, нийт 18 ТХГН-ийн хамгаалалтын захиргааны төлөөлөл хамрагдсан болно. **Ажлын гүйцэтгэл 100%**<br><br>**4.04 ЮНЕСКО-гийн Дэлхийн өв, Хүн ба шим мандлын нөөц газарт бүртгүүлэх тусгай хамгаалалттай газар нутгийн тухай контент, баримтат кино бүтээх ажлын хүрээнд /ҮАТ 4.04/:**<br>2023 онд сонгон шалгаруулалтыг явуулж, ""Байгаль, зэрлэг амьтан хамгаалах үндэсний нийгэмлэг НҮТББ-тай 2024.01. 11- ний өдөр байгуулсан №24/14 тоот 72,500,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу гүйцэтгэгч нь 2024.11.20-ны өдөр 3 минутын 5 контентын зохиолыг ирүүлсэн захиалагчаас санал авах шатандаа байна. 10 минутын нэгдсэн контентын зохиолыг 12 сард багтаан танилцуулахаар төлөвлөн ажиллаж байна. Дэлхийн өв гэж юу болох, Монголын говийн хосгүй үнэ цэнийг харуулсан ховор содон амьтан, ургамал, байгалийн төрх онцлог зэргийг багтаасан 3 минут үргэлжлэх богино хэмжээний 5 ширхэг цуврал контентыг Монгол хэл дээр (англи хадмалтайгаар), 10 минут үргэлжлэх 1 ширхэг бүрэн хэмжээний баримтат нэвтрүүлгийг англи хэл дээр тус тус техникийн шаардлагын дагуу гүйцэтгэж, 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 2025/04 дугаартай актаар захиалагчид актаар хүлээлгэн өгсөн. **Ажлын гүйцэтгэл 100%, төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн.**<br><br>**4.06 Монгол орны ТХГН-ийн сүлжээний хэмжээнд мэдээллийн санг стандартын дагуу байгуулах /ҮАТ 4.06/:**<br><br>БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны №А/321 тушаалын дагуу тендерийн үнэлгээний хороог байгуулж, сонгон шалгаруулалтыг ТБОНХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулсан.<br>Тендерийн ялагч "Битсофт" ХХК-тай 2024.05.22-ны өдөр | 97 |

| | | | |
|---|---|---|---|
| | | байгуулсан №24/174 тоот 69,000,000.00 төгрөгийн үнийн дүн бүхий зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу гүйцэтгэгчийн ажил хангагдсан ба сүлжээ серверийн холболтын асуудлыг захиалагчаас 2024.09.27-ны өдөр гаргаж өгсний дагуу холбох ажил болон сургалтын бэлтгэл ажлыг гүйцэтгэсэн. Гэрээний дагуу эцсийн тайланг 2025.02.20-ний өдөр ирүүлсэн , Захиалагч буюу БОУАӨЯ-ны ТХГНБХГ-ын хамтран 2024.11.08-ны өдөр талуудын уулзалтыг хийсэн бөгөөд эхлэлийн тайланг хүлээн авч эхний санхүүжилтийг олгож 11 дүгээр сард багтаан ажил дуусгахаар тохиролцож хурлын тэмдэглэл үйлдсэн. Гүйцэтгэгч нь 2024.11.30, 2024.12.19, 26-ны өдрүүдэд холбогдох сургалтуудыг зохион байгуулаад байна. Эцсийн тайлан хүлээн авах хурлыг 2025.04.17-ны өдөр зохион байгуулж захиалагч гүйцэтгэлийг актаар хүлээн авав. Гэрээний дагуу гүйцэтгэл хангагдаагүй хугацааны алдангийг тооцож, гэрээ дүгнэсэн актыг баталгаажуулахаар БОУАӨЯ-ны ТНБД-д хүргүүлээд байна. **Ажлын гүйцэтгэл 90%.** | |
| 14 | Байгаль орчин, нийгмийн менежмент | **5.01 Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудад БОНМ урьдчилсан үнэлгээ/үнэлгээ, БОНМТ/БОНМЗ боловсруулах ажлын хүрээнд /ҮАТ 5.01/:**<br>Анхны зураг төсөвт үндэслэсэн ss-ESMP төлөвлөгөөг 2023 онд KfW албан ёсоор баталсан. Гэсэн хэдий ч зураг төсөлд орсон өөрчлөлтүүдийн дагуу уг баримт бичгийг шинэчлэн боловсруулж, дахин KfW-д батлуулахаар хүргүүлсэн. Үнэлгээний үр дүнгээр уг хөрөнгө оруулалт нь байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөлөл багатай гэж дүгнэгдсэн. Шинэчилсэн ss-ESMP-д барилгын үеийн эрсдэлийг бууруулах тусгайлсан арга хэмжээнүүдийг тусгасан бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэх явцад KfW-ийн шаардлага болон Монгол Улсын холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтыг чанд мөрдөх нь нэн чухал байна.<br><br>Байгаль хамгаалагчийн байрны БОНМ-ийн асуудал<br>Төслийн Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээ баримт бичигт үндэслэн Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны дүрэм (БОНҮАД) боловсруулагдсан. Байгаль хамгаалагчийн барилга нь цар хүрээний хувьд хязгаарлагдмал, хүн ам суурьшаагүй бүсэд байрлаж буй тул зарим заалтыг зохих ёсоор хассан болно. БОНҮАД батлагдсаны дараагаар уг баримт бичгийг төслийн зураг төсөл болон худалдан авалтын холбогдох баримт бичгүүдэд нэгтгэн тусгах бөгөөд хэрэв KfW-ийн худалдан авалтын стандарт загварыг ашиглаж буй бол БОНҮАД нь Байгаль орчин, нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлын | 50 |

| | | | |
|---|---|---|---|
| | | техникийн тодорхойлолтын “В хүснэгт”-ийг орлох зориулалттай. Харин үндэсний худалдан авалтын журам мөрдөгдөж буй нөхцөлд БОНҮАД нь Монгол Улсын холбогдох эрх зүйн зохицуулалтад нийцүүлэн уялдуулж, өөрчлөгдөнө. Мөн газар ашиглалт болон байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (ESIA)-тэй холбоотой асуудлуудыг тодорхой болгох үүднээс Байгаль орчин, нийгмийн менежментийн баг БОУАӨЯ-тай нягт хамтран ажиллаж байна.<br><br>2 ажил 50% (хэрэгжих шатандаа), **Байгаль орчин, нийгмийн менежментийн ажлын дундаж үнэлгээ 50%. Үнэлэхгүй, хэрэгжилтийн хугацаа болоогүй** | |
| 15 | Төсөл хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн аудит | **6.01 Төслийн 2024 оны үйл ажиллагаанд баталгаажуулалтын аудит болон санхүүгийн тайлангийн аудит хийлгэх гэрээ байгуулж, гүйцэтгүүлэх (үргэлжилж буй)/ҮАТ 6.01/:**<br>Үндэсний аудитын газрын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 07/354 дугаартай албан тоотын дагуу төслийн II,III шатны 2024 оны үйл ажиллагаанд санхүүгийн аудит, санхүүгийн хянан баталгаажуулалтыг хийх ажлын ҮАГ/АА-2025-06 дугаартай гэрээг “Үндэсний аудитын газар”, “Мишээл-од аудит” ХХК-тай байгуулж ажилласны дагуу аудитын тайланг 2025 оны 02 дүгээр сарын 10-ны өдөр Үндэсний аудитын газар хүргүүлсэн. Аудитын шалгалтаар төслийн II/III шатанд Хязгаарлалттай дүгнэлт буюу 2 албан шаардлага, 4 зөвлөмжтэй аудитлагдаж санхүү эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгдсэн тайланд нэгтгэгдсэн. | |
| **Төслийн ерөнхий менежмент** | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 16 | Төслийн ерөнхий менежмент | **1. 2025 оны ажлын үйл ажиллагааны болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж тус тус батлуулах ажлын хүрээнд /PM01/:**<br>Төслийн 2025 оны үйл ажиллагааг төлөвлөж дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Төслийн УХ-ны XIX дэх хурлыг 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр, XX дах хурлыг 04 дүгээр сарын 30-ны өдөр тус тус зохион байгуулснаар ҮАТ-ний төслийг танилцуулж, хэлэлцүүлэн, нийт 47 үйл ажиллагааг төлөвлөн 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр УХ-ны даргаар батлуулсан. **Ажлын гүйцэтгэл 100%.**<br><br>**2. УЗ-ийн хурлыг зохион байгуулж, цаг үеийн асуудлаар холбогдох шийдвэрлүүлэх ажлын хүрээнд /PM02/:**<br><br>Төслийн УХ-ны XIX дэх хурлыг 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулж 2024 оны 10-11 дүгээр саруудад төслийн үйл ажиллагаанд хийгдсэн kfw банкны хөндлөнгийн үнэлгээ, түүний үр дүнд өгөгдсөн үүрэг даалгавар тэдгээрийн биелэлтийг танилцуулсан. БОУАӨЯ-ны ТНБД-ын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/191 дугаартай Төслийн удирдах хорооны гишүүдийг шинэчлэн байгуулах тухай тушаалаар 4 байгууллагын 11 гишүүдийн төлөөлөл бүхий Шинэчилсэн удирдах хороог байгуулсан. Тус удирдах хорооны анхдугаар хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулж, төслийн 2025 оны ҮАТ-ны төсөл, KfW банкны үнэлгээ, БОУАӨЯ-ны ХШҮДАГ-ын төслийн 2022-2025 оны үйл ажиллагаанд хийсэн ХШҮ-ны тайланг хэлэлцүүлж ажилласан. Хурлаас гарсан шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. **Ажлын гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу 100%.**<br><br>**Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөний Төслийн ерөнхий менежментийн ажлын хүрээнд** нийт 3 ажил төлөвлөснөөс 2 ажил 100% үнэлэгдэж байна. KfW банкнаас Төслийн явцын үнэлгээний баг ирж ажиллах ажлын хүрээнд /PM03/: ажил хугацаа болоогүй учир үнэлэхгүй.<br>Төслийн ерөнхий менежментийн дундаж үнэлгээ 100%. | 100 |
| | **Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежмент, мониторинг** | **Төслийн хяналт үнэлгээ, мониторингийн сургалт хийх ажлын хүрээнд /M05/:**<br>Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх, зорилго бүхий хяналт-мониторинг сургалтыг үе шаттайгаар төслийн зөвлөх баг төлөвлөн хэрэгжүүлж байна. Тус ажлын хүрээнд олон улсын зөвлөх хатагтай Фридрика Лемме 2025 оны гуравдугаар сард Монгол Улсад хүрэлцэн ирж, дээрх сургалтуудыг Өмнөд болон Баруун бүсийн холбогдох ТХГН-ийн төлөөллийг хамруулан амжилттай зохион байгуулсан болно. ТХГН-ийн хамгаалалтын захиргаадын ХШҮ хариуцсан | |

| | | | |
|---|---|---|---|
| 17 | | ажилтнуудын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор зөвлөх баг сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн. Энэхүү чадавхыг бэхжүүлэх сургалтыг 2025 оны гуравдугаар сарын 10–20-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд сургалтууд Өмнөд болон Баруун бүсийн төвд зохион байгуулагдаж, нийт 18 ТХГН-ийн хамгаалалтын захиргааны төлөөлөл хамрагдсан болно.<br>**Ажлын гүйцэтгэл 100%**<br><br>**Бусад ажлын хүрээнд.**<br>Төслийн үйл ажиллагаанд Санхүүжүүлэгч тал, Захиалагч талуудаас хийсэн 2 удаагийн хөндлөнгийн үнэлгээ, хяналт шалгалтын ажлын тайлан, зөрчил, зөвлөмжийн биелэлтийг ханган, тайлагнан ажиллаж байна. Эдгээр ажлуудын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр 2025 оны ХШҮ-ний төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Тус төлөвлөгөөний төслийн ерөнхий үйл ажиллагаа болон төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр нөлөөг үнэлэх ажлуудыг зөвлөх ба, орон нутагтай хамтран хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн Үүнд:<br><br>1. Төслийн мэдээлэл тайлан бүрдүүлэлт, ил тод байдлыг хангах ажлын хүрээнд:<br>- 2024 оны ҮАТ-ны тайлан<br>- 2024 оны ХШҮ-ний тайлан<br>- 2025 оны УХ-ных хурлын шийдвэр, зөвлөмж<br>- 2025 оны Төслийн үйл ажиллагаанд захиалагч талаас хийсэн ХШҮ-тайлан, шийдвэрүүд.<br>- 2025 оны ХШҮ-ний төлөвлөгөө<br>- 2025 оны ҮАТ, ХААТ төлөвлөгөө зэрэг бусад дутуу тайлан мэдээг хавсарган нийт 8 төрлийн 10 мэдээ оруулж баталгаажуулсан.<br>- Төслийн bаccp.mn цахи хуудсанд үнэлгээ хийж дутуу мэдээллүүдийг нөхөн оруулсан.<br><br>2. Мониторинг матриксийн индикатортай уялдуулан Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх ажлын хүрээнд:<br>- ХШҮ-ний баг төслийн нөлөөллийн хяналт-шинжилгээнд ашиглах бүтцийн асуумжуудыг Kobo Toolbox платформ дээр боловсруулж, ашиглалтын туршилтыг 2025 оны 06 дугаар сарын 26-28ны өдрүүдэд Их газрын чулууны БЦГ, түүний орчны бүсийн төсөлд хамрагдсан байгууллагуудыг хамруулсан хийсэн. Бүх асуумж судалгааг оролцогч талуудаас авч боловсруулан төслийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын мэдээллийн бааз, мөн үр нөлөөллийг суурь судалгаа, шалгуур | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | үзүүлэлттэй уялдуулан эхний байдлаар үнэлэх юм.<br>3. Төслийн хүрээнд өгөгдсөн хөрөнгө оруулалт тэдгээрийн ашиглалт, хэрэгцээнд мониторинг хийх ажлын хүрээнд:<br>- Төслийн хүрээнд өгөгдсөн хөрөнгө оруулалтын тоон болон хуваарилалтын нэгдсэн дата баазыг шинэчлэх, цаашид тогтмол уялдаа холбоотой бүртгэлжүүлэх чиглэлээр зөвлөх багтай хамтран ажиллаж, нэгдсэн системтэй болсон. Цаашид худалдан авалт, гэрээ болон хүлээлгэн өгсөн хөрөнгө оруулалтуудыг нэгтгэн мэдээллийн бааз, ашиглалтад хяналт тавин ажиллана.<br>- БОУАӨЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн 09/2577 дугаартай албан бичгийг хөрөнгө хүлээн авсан Байгаль орчны салбарын болон орон нутгийн өмчит нийт 147 байгууллагад хүргүүлэн өмч бүртгэлийн тайлан мэдээг нэгтгэн ажиллаж байна.<br>- Төслийн 2025 оны орон нутагт ажиллах төлөвлөгөөг зөвлөх багтай хамтран боловсруулж төслийн хүрээнд хөрөнгө оруулалтын дэмжлэг авсан бүх байгууллагуудын хөрөнгө ашиглалтад хяналт тавих, үр нөлөөг үнэлэх зорилготой хяналт-мониторингийн маршрутыг боловсруулсан батлуулсан. Эхний хяналт-мониторинг ажлыг 2025 оны 06 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд Дундговь аймаг, Их газрын чулууны БЦГ, түүний орчны бүсийн байгууллагуудад хийсэн.<br>**Төслийн Мониторинг, БОННМ-ийн дундаж үнэлгээ 100%.** | |
| 18 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт | Төслийн хүрээнд 2025 онд нийт 12 тушаалыг албажуулснаас 4 тушаал нь БОУАӨ-ын сайдын тушаал, 8 тушаал нь Төрийн нарийн бичгийн даргын тушаал байна. Нийт тушаалын 8 нь буюу 67 % нь төсийн хүний нөөц, бүтцийн тухай тушаал байна. Төслийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой 4 тушаал гарсан. Төслийн үйл ажиллагаа, хүний нөөцийн томилгоотой холбоотой тушаалын биелэлтийн тайланг 2025 оны 06 сарын 05-ны өдрийн байдлаар БОУАӨЯ-нд тайлагнасан. | |
| **Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн чадамжийн үнэлгээ** | | | |
| 19 | Хүний нөөцийн үйл ажиллагааны дахь чадахуйн | Төслийн албан хаагчдын чадавхжуулах БОУАӨЯ, СЯ, болон бусад байгууллагуудаас зохион байгуулж буй арга хэмжээнд ажилтан нарыг дэмжин ажилладаг. Тайлант хугацаанд төслийн үйл ажиллагааг хурдан шуурхай зохион | |

| | | | |
|---|---|---|---|
| | зарчмын хэрэгжилт | байгуулах зорилгоор төслийн 5 ажилтныг Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад хамруулах хүсэлтийг 2025 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн 25/26 дугаартай хүсэлт өгч, Худалдан авах ажиллагааны хөтөч газартай хамтран зохион байгуулж төслийн ажилтан нар ээлжлэн сургалт арга хэмжээнд хамрагдаж байна. | 100 |
| 20 | Санхүүгийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт | Аудитын шалгалтаар төслийн II/III шатанд Хязгаарлалттай дүгнэлт буюу 2 албан шаардлага, 4 зөвлөмжтэй аудитлагдаж санхүү эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгдсэн тайланд нэгтгэгдсэн. Үүнээс 2025 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн 25/23 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт 1 хугацаатай албан шаардлагын биелэлтийг хүргүүлсэн. 2025 оны 09 дүгээр сард үлдсэн биелэлт, хэрэгжилтийг тайлагнахаар төлөвлөн ажиллаж байна (хэрэгжих шатандаа), **Үнэлэхгүй, хэрэгжилтийн хугацаа болоогүй.** | |
| 21 | Хяналт-шинжилгээний зөвлөмжийн хэрэгжилт | 1. Төслийн үйл ажиллагаанд KfW банкны хөндлөнгийн үнэлгээний тайланг өгөгдсөн хугацаатай өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай санхүүжүүлэгч талд тайлагнаж ажилласан. Төслийн ҮАТ-ний дагуу дараагийн 2025 оны хөндлөнгийн үнэлгээний баг ирэх 08-09 дүгээр сарууддад ирж ажиллана. Тус үнэлгээний багт биелэлт хэрэгжилтийн тайланг танилцуулна.<br>2. Төслийн 2024 оны ХШҮ-ны тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу эрсдэл бүхий засаж сайжруулах 11 ажил байна. Эдгээр ажлын биелэлт, тайлбарыг ХШҮ-ний хагас жилийн тайланд хавсралтаар тайлагнасан.<br>3. БОУАӨЯ-ны ХШҮДАГ-аас төслийн 2022-2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-мониторинг тайланд өгөгдсөн 16 дүгнэлт, 8 зөвлөмж өгөгдсөн. Тус хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд илэрсэн зөрчил, зөвлөмжийн биелэлт, тайлбарыг боловсруулан зөвлөх багт хүргүүлсэн. Талуудад танилцуулсны дараа санхүүжүүлэгч тал KfW банканд хүргүүлнэ. Зөвлөмжийн | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | биелэлтийг жилийн эцсийн удирдах хорооны хуралд тайлагнана. | | |
| 22 | Нэмэлт оноо | Байгууллагын үйл ажиллагааны ерөнхий дүнгийн өөрчлөлт (+ оноо) | | 2 |
| | | **Тайлан** | | |
| 23 | | **1. Хагас жил, бүтэн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргаж БОАЖЯ, СЯ-д хүргүүлэх/ R01/:**<br>Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Төслийн II,III шатны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жилийн байдлаар тус тус гаргаж, төслийн 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 25/30 дугаартай албан бичгээр БОУАЯ-ны УАӨБТГ-ын ГХАХ-т хүргүүлсэн.<br><br>Санхүүгийн ерөнхий тайлан:<br>• НӨАТ-ын тайланг цаасаар болон цахим хэлбэрээр сар бүр хийж Татварын ерөнхий газарт хүргүүлж байна.<br>• Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан сар бүр боловсруулан Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлж байна.<br>• Хүн амын орлогын албан татварын тайланг сар бүр боловсруулан Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст хүргүүлж байна.<br><br>**2. Улирал, хагас жил, бүтэн жилийн үйл ажиллагааны тайланг KfW банканд илгээх/ R02/:**<br>Төслийн үйл ажиллагааны тайланг улирал тутамд KfW-банканд, худалдан авах ажиллагааны тайланг сар тутам БОАЖЯ-ны СХОХ-т, санхүүгийн үйл ажиллагаа, ашиглалтын тайлан мэдээг сар бүр СЯ-нд тус тус тайлагнасан.<br><br>**3. Тусгай дансны татан авалт, зарцуулалтын тайланг KfW банкинд илгээх ажлын хүрээнд /R.03/:**<br>Төслийн II үе шатны татан авалтын тайланг 2025 оны төлөвлөгөө 2025 оны 06 сарын 18-ний өдөр батлагдсантай холбоотой донортой зөвшилцсөний дагуу 2024 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 30-ний өдрөөр таслан 2025 оны 08 дугаар сард ХБНГУ руу хүргүүлэхээр ажиллаж байна.<br><br>**4. Шилэн данс /www.shilen-dans.mn/-д худалдан авалт болон санхүү, мониторингийн тайланг илгээх ажлын хүрээнд /R.04/:**<br>Төслийн үйл ажиллагааны хүрээнд гарсан тушаал, шийдвэрүүдийг БОУАӨ-ийн сайдын 4 тушаал, ТНБД-ын 8 | |

<table>
<tr><td></td><td></td><td colspan="6">тушаал, Сангийн яамны ТНБД-ийн 1 тушаал нийт 13 тушаал шийдвэрийг Шилэн дансанд, УМС, eic.mn цахим системүүдэд оруулж ажилласан. Мөн төслийн хүрээнд тайлант хугацаанд УМС-д үйл ажиллагаа, ХШҮ, болон бусад зөвлөмж, шийдвэртэй холбоотой 7 төрлийн 10 тайланг тайлагнасан.</td><td></td></tr>
<tr><td>24</td><td>Дүгнэлт (ололт, амжилт, дутагдал, анхаарах асуудлууд)</td><td colspan="6">Цаашид анхаарах асуудлууд, дутагдал:<br>1. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө 06 сарын 18-ны өдөр баталгаажсантай холбоотой ажлын даалгавруудыг төлөвлөсөн хугацаанд баталгаажуулах шаардлагатай байна. Ажлын даалгавар боловсруулалтыг үйл ажиллагаа болон худалдан авалтын төлөвлөгөөнд туссан байдлыг үнэлэхэд 06 дугаар сард 1 ажил, 07 дугаар сард 8 ажил, 08 дугаар сард 4 ажил, 09 дүгээр сард 1 ажил, 10 дугаар сард 1 ажил тус тус төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний дагуу 06 болон 07 сард захиалагч талаар баталгаажуулан ТХН-д хүлээлгэн өгөх 9 ажлаас албан ёсоор баталгаажиж ирсэн ажлын даалгавар байхгүй байна. Энэ нь үйл ажиллагааны хэрэгжилтийг удаашруулах, үнэлэлтийг бууруулах эрсдэлтэй байна.<br>2. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө захиалагч талд 45 хоног хянагдаж оны хагас жилээр баталгаажсан, голлох худалдан авах ажиллагаа, тендер зохион байгуулалт хийгдэх үеүдэд захиалагч талын болох БОУАӨ-ийн сайд солигдсон нь цаашдын газар хэлтсийн мэргэжилтэн нарт өөрчлөлт орох эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь төслийн үйл ажиллагааг удаашруулах, гарын үсгийн баталгаа, гэрээ, тайлан баталгаажуулалтыг цаашлаад санхүүжилтийг удаашруулахад нөлөөлнө.<br>3. Мөн үйл ажиллагааг хэрэгжүүлэх голлох үе болох 07-08 саруудад бүх нийтийн амралт, БОУАӨЯ-ны албан хаагчдын амралт эхэлж буй нь ажил удаашрахад нөлөөлнө.</td><td></td></tr>
<tr><td rowspan="2">25</td><td rowspan="2">Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (Өөрийн үнэлгээ)</td><td>Менежмент</td><td>Зорилт 1</td><td>Зорилт 2</td><td>Зорилт 3</td><td>Зорилт 4</td><td>БОННМ Мониторинг</td><td rowspan="2">95</td></tr>
<tr><td>100</td><td>95</td><td>92</td><td>90</td><td>97</td><td>100</td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт 3 ажил: 2ажил 100% 1 ажил хугацаа болоогүй | Нийт 5 ажил: 2 ажил 100%, 2 ажил 90%, 1 ажил 70% | Нийт 13 ажил: 2 ажил 90%, 2 ажил 70%, 5 ажил 0%,1 ажил 8 үнэлэхгүй | Нийт 11 ажил: 2 ажил 90%, 7 үнэлэхгүй | Нийт 10 ажил: 2 ажил 100%, 1 ажил 90 %, 7 үнэлэхгүй | Нийт 2 ажил: 3 ажил 100%, | |
| | | **2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө 06 дугаарын 18-ны өдөр, ХАТ 06 дугаар сарын 20-ны өдөр тус тус баталгаажсан** нийт 47 ажил төлөвлөснөөс ТХН-ийн дотоод болон хугацаа болоогүй ажлыг үнэлээгүй тул он дамнан хэрэгжсэн 10 гэрээт ажил, бусад үйл ажиллагааны 5 ажил **нийт 15 ажлыг үнэлсэн.** | | | | | | |
| 24 | Ерөнхий дүн: | 95 хувь | | | | | | |

**ХЯНАСАН:**
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ: М.Тулга

**БОЛОВСРУУЛСАН:**
ТӨСЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН: Г.Сайнбаяр